



ФЕМИДА МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ОНЫ ЖИЛИЙН ОР 2023



ОНЫ ШИЛДЭГ ХУУЛЬЧДЫГ ШАЛГАРУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ОНЫ ШИЛДЭГ ХУУЛЬЧИД НЭР ДЭВШИГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Монгол Улсын хууль зүйн салбарт ажиллаж буй хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх, хуульчийн мэргэжлийн үүрэг, ёс зүй, нэр хүндийг өндөрт өргөх чиглэлээр нийгэмд үлгэр дуурайл болж, мэргэжлээрээ манлайлсан, Монголын Хуульчдын холбооны хөгжил, төлөвшилд үнэтэй хувь нэмэр оруулж буй “Оны шилдэг хуульч”-ийг тодруулахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

Хоёр. Шагналын төрөл, нэр дэвшүүлэх

2.1. Оны шилдэг хуульчдыг дараах төрлөөр шалгаруулна. Үүнд:

- 2.1.1. “Шилдэг хуульч-Эрдэмтэн” ;
- 2.1.2. “Шилдэг хуульч-Шүүгч” ;
- 2.1.3. “Шилдэг хуульч-Прокурор” ;
- 2.1.4. “Шилдэг хуульч-Өмгөөлөгч” ;
- 2.1.5. “Шилдэг хуульч-Нотариатч” ;
- 2.1.6. “Шилдэг хуульч-Хуулийн зөвлөх” ;
- 2.1.7. “Шилдэг хуульч-Мэргэжилтэн” ;
- 2.1.8. “Шилдэг Про-боно хуульч” ;
- 2.1.9. “Шилдэг салбарын зохицуулагч” ;
- 2.1.10. “Шилдэг хуульч-Улсын өмгөөлөгч” ;
- 2.1.11. “Шилдэг залуу хуульч” ;
- 2.1.12. “Шилдэг өмгөөллийн нөхөрлөл” ;
- 2.1.13. “Шилдэг хороо” ;

2.2. Оны шилдэг хуульчдыг дараах байдлаар нэр дэвшүүлнэ.

- 2.2.1. “Шилдэг хуульч-Эрдэмтэн”-д Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хороо 3 хүртэлх хуульч эрдэмтний;
- 2.2.2. “Шилдэг хуульч-Шүүгч”-д Шүүгчдийн хороо 3 хүртэлх шүүгчийн;
- 2.2.3. “Шилдэг хуульч-Прокурор”-т Прокурорын хороо 3 хүртэлх прокурорын;
- 2.2.4. “Шилдэг хуульч-Өмгөөлөгч”-д Өмгөөлөгчдийн хороо 3 хүртэлх өмгөөлөгчийн;
- 2.2.5. “Шилдэг хуульч-Нотариатч”-д Нотариатчдын хөгжлийг дэмжих хороо 3 хүртэлх нотариатчийг;
- 2.2.6. “Шилдэг хуульч-Хуулийн зөвлөх”-д аж ахуйн нэгж, компани нь 1 хүртэлх хуульчийн;
- 2.2.7. “Шилдэг хуульч-Мэргэжилтэн”-д төрийн байгууллага 1 хүртэлх хуульчийг;



ФЕМИДА МОНГОЛЫН ХУУЛЬЧИЙН ХОЛБООНЫ 40 ЖИЛИЙН ОР 2023



ОНЫ ШИЛДЭГ ХУУЛЬЧДЫГ ШАЛГАРУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

- 2.2.8. “Шилдэг Про-боно хуульч”-д Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн хороо болон Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо тус бүр 2 хүртэлх хуульчийн;
- 2.2.9. “Шилдэг салбарын зохицуулагч”-д Монголын Хуульчдын холбооны Тамгын газраас 3 хүртэлх хуульчийн;
- 2.2.10. “Шилдэг хуульч-Улсын өмгөөлөгч”-д Хууль зүйн туслалцааны төв 3 хүртэлх улсын өмгөөлөгчийн;
- 2.2.11. “Шилдэг залуу хуульч”-д 35 хүртэлх насны хуульч өөрийн нэрийг;
- 2.2.12. “Шилдэг өмгөөллийн нөхөрлөл”-д Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хороо 3 хүртэлх өмгөөллийн нөхөрлөлийг;
- 2.2.13. Шилдэг хороонд Хуульчдын холбооны хороод өөрийн нэрийг тус тус дэвшүүлнэ.

Гурав. Нэр дэвшигчид тавих шаардлага

- 3.1. Удирдамжийн 2.2.9, 2.2.12, 2.2.13-г зааснаас бусад нэр дэвшигч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 3.1.1. мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх /уг заалт нь шилдэг залуу хуульчид нэр дэвшигчид хамаарахгүй болно/;
 - 3.1.2. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг сүүлийн 5 жил тасралтгүй эрхэлж байгаа;
 - 3.1.3. хуульчийн мэргэжлийн хариуцлага, ёс зүйн зөрчилгүй байх /тухайн байгууллагын захиргаа, сахилгын арга хэмжээ үүнд хамаарна/;
 - 3.1.4. Хуульчдын холбооны гишүүний үүргийн зөрчилгүй байх;
 - 3.1.5. Хуульчдын холбоо, хорооны үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцсон байх /олон нийтийн арга хэмжээ, хэлэлцүүлэг, хурал, өдөрлөг, сургалт, семинар, бусад ажил/;
- 3.2. Зарим нэр дэвшигчид дараах тусгай шаардлагыг хангасан байна.
 - 3.2.1. “Шилдэг хуульч-Эрдэмтэн”-д нэр дэвшигч нь эрх зүйн аль нэг салбар чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг, нэг сэдэвт болон хамтарсан бүтээл гаргаж, бүтээл нь мэргэжлийн сэтгүүл, ном болон хэвлэгдсэн байх, эрх зүйч бэлтгэдэг их, дээд сургуульд багшилж байгаа;
 - 3.2.2. “Шилдэг Про-боно хуульч”-д нэр дэвшигч нь тухайн жилд 2-оос доошгүй төлбөрийн чадваргүй иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа үзүүлсэн байх, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаанд оролцсон байх;
 - 3.2.3. “Шилдэг хуульч-Хуулийн зөвлөх”-д нэр дэвшигч нь Монгол Улсад бүртгэлтэй 2018 оноос өмнө үүсгэн байгуулагдсан, ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд болон Төрийн бус байгууллагад орон тооны хуулийн зөвлөх, хуульчаар ажиллаж байгаа;



ФЕМИДА МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ 403 ЖИЛИЙН ОР 2023



ОНЫ ШИЛДЭГ ХУУЛЬЧДЫГ ШАЛГАРУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА


- 3.2.4. “Шилдэг хуульч-Мэргэжилтэн”-д нэр дэвшигч нь Төрийн захиргааны аль нэг байгууллагад ажилладаг байх;
- 3.2.5. “Шилдэг залуу хуульч”-д нэр дэвшигч нь 35-аас доош насны байх;
- 3.3.6.” Шилдэг-Өмгөөллийн нөхөрлөл”-д нэр дэвшүүлэх үйл ажиллагааг Хуульчдын холбооны Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хороо зохион байгуулна.

Дөрөв. Бүрдүүлэх материал, хүлээн авах

- 4.1. Шилдэг хуульчид нэр дэвшигчийн материалд дараах баримт бичгийг хавсаргана:
 - 4.1.1. Хуульчийн нэгдсэн бүртгэлийн анкет; /татаж авах/
 - 4.1.2. Хоёр хувь цээж зураг /3x4 хэмжээтэй/;
 - 4.1.3. Тодорхойлолт /ажил олгогчийн тодорхойлолт эсхүл 2-оос доошгүй хамтран ажиллагчийн тодорхойлолт байх/;
 - 4.1.4. Хорооны Удирдах зөвлөлийн хурлын шийдвэр;
 - 4.1.5. Бусад /зарим нэр дэвшигч нь тусгай шаардлагыг хангасан тухай бусад баримт бичиг/.
- 4.2. “Шилдэг – Өмгөөллийн нөхөрлөл”-д нэр дэвшигчийн материалд дараах баримт бичгийг хавсаргана:
 - 4.2.1. Өмгөөллийн нөхөрлөлийн мэдээлэл /Маягт 1-ийн дагуу/;
 - 4.1.2. Байгууллагын гэрчилгээний хуулбар;
 - 4.1.3. Хуульчдын мэдээлэл
 - 4.1.4. Нийтийн эрх ашгийг хамгаалах, Про-боно үйл ажиллагааны талаарх мэдээлэл;
 - 4.1.5. Хуульчдын холбооны үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцсон байдал /хэлэлцүүлэг, сургалт, семинар зэрэг олон нийтэд чиглэсэн арга хэмжээ, үйл ажиллагаанд хамтран болон дэмжиж оролцсон байдал/;
 - 4.1.6. Бусад /дээр дурдсанаас бусад онцлох үйл ажиллагааны талаар/.
- 4.3. Нэр дэвшигчдийн удирдамжид заасан шаардлага бүрэн хангасан материалыг 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 17:30 цагт хүртэл Хуульчдын холбооны 403 тоотод цаасаар болон info@mglbar.mn цахим хаягаар хүлээн авна. Мэдээлэл лавлах утас: 70116364 (6).

Тав. Сонгон шалгаруулах

- 5.1. Оны шилдэг хуульч, нөхөрлөл, хороог шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар байгуулна.
- 5.2. Тамгын газрын мэргэжилтэн нь удирдамжид заасан шаардлага хангасан нэр дэвшигчдийн материалыг ажлын хэсэгт хүргүүлнэ.
- 5.3. Ажлын хэсэг энэхүү удирдамжийн 2.1-т заасан төрөл тус бүрээр шилдгүүдийг шалгаруулахдаа дараах шалгуур үзүүлэлтийг харгалзана.





ФЕМИДА МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ 12-ЖИЛИЙН ОР 2023



ОНЫ ШИЛДЭГ ХУУЛЬЧДЫГ ШАЛГАРУУЛАХ ЁСЛОЛЫН АЖИЛЛАГАА

- 5.3.1. Удирдамжийн 3 дугаар бүлэгт заасан ерөнхий болон тусгай шаардлагыг хангасан эсэх;
- 5.3.2. Удирдамжийн 3.1.4-т заасан шаардлагыг буюу хуульчийн нийтлэг үүргийн биелэлтийг үнэлэхдээ гишүүний татвар төлөлт, хуульчийн үргэлжилсэн сургалтад хамрагдсан байдлыг харгалзана;
- 5.3.3. Хуульчдын холбоо, хорооны чиг үүрэг, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг цаг тухайд нь хэрэгжүүлсэн байх, холбооноос өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр чанартай гүйцэтгэсэн байх;
- 5.3.4. Хуульчдын холбоо болон өөрийн гишүүнчлэлтэй хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, ажлын үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр шинэ санаа, санаачилга гаргасан эсэх;
- 5.3.5. Хууль, дүрэм, журам бусад баримт бичгийн төсөл боловсруулахад оролцсон, уг ажлын хэсэгт орж ажилласан, өөрийн зүгээс санал, дүгнэлт гаргасан байх;
- 5.3.6. Хуульчдын холбооноос зохион байгуулсан олон улсын болон дотоодын хуралд илтгэл хэлэлцүүлсэн, оролцсон, ном гарын авлага бичсэн, орчуулсан, хуульчдад хичээл, сургалт заасан болон бусад олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцсон байх.
- 5.4. Ажлын хэсгээс хуульчдад шагналыг олгуулахаар холбогдох материалыг хавсарган холбооны Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

Зургаа. Шагнал

- 6.1. Шагналд Монголын Хуульчдын холбооны нэрэмжит шагнал буюу “Фемида”, оны шилдэг хуульчийн өргөмжлөл багтана.
- 6.2. Шагналыг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар “ФЕМИДА-2023” шилдэг хуульч шалгаруулах ёслолын ажиллагааны үеэр буюу 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр гардуулна.

ooOoo

